


ИХ намын Улс төрийн зөвлөлийн
2020 оны 06-р сарын 22-ны өдрийн
хурлаар батлав.



**ИХ НАМЫН АЙМАГ БОЛОН СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ИХ
НАМЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**“БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ 2030”
ЭРХЭМ ЗОРИЛГО**

1. Орон нутгийн бүтээн байгуулалтыг иргэдийн оролцоотойгоор өрнүүлж 2024 онд бүс нутагтаа тэргүүлэгч улс үндэстэн болох.
2. Монгол Улсын иргэнд тулгамдсан асуудал бол аймаг, нийслэл, сум, дүүргийн тулгамдсан асуудал гэсэн гол зарчмыг мөрдлөг болгож, оновчтой хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжүүлэх замаар, үргүй зардлыг бууруулна.
3. Шударга, хөгжингүй улс болгох гол хүч болсон Монгол хүнийг үндэсний үнэт зүйлтэй, эв нэгдэлтэй, бие биенээ харилцан дэмжин хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн иргэнд суурилсан эрүүл бодлогыг баримталж ажиллана.
4. Ил тод, нээлттэй, эрх чөлөөтэй, ардчилсан, хариуцлагатай, иргэддээ бүрэн эрхийн бололцоог олгосон, бүх шатанд ил тод нээлттэй засаглалыг бий болгохыг эрмэлзэн ажиллана.
5. Орон нутгийн хөгжилд Хөдөө аж ахуй, Аялал жуулчлалын салбарыг чухалчлан авч үзэж суурь эдийн засгийн салбар болгон хөгжүүлэх бодлогыг баримталж ажиллана.
6. Орон нутгийн нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд нөлөөлөх, оролцох иргэдийн идэвхтэй, эерэг хандлагатай оролцоог нэмэгдүүлнэ.
7. Үндэсний өнгө төрхтэй иргэндээ ээлтэй, аюулгүй сууринг иргэдийн дэмжлэгтэй байгуулна.

Handwritten signatures and stamps in red ink, including a stamp with the number 6417143544 and ВЮА0067 9007.

**“БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ 2024”
БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

Энэхүү мөрийг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах суурь зарчмыг баримтална.

- Аливаа залгамж халаатай, үүслийг үргэлжлүүлэх бүтээлч санаачилга бол хөгжлийн үндэс гэж үзнэ.
- Нэг иргэн нэг амьдрал гэсэн суурь зарчмыг мөрдлөг болгож, хүн бүрийг гэр бүл, хамт олонд нь хариуцуулж, “Бусдын алдаа надаас болдог, хохирол нь намайг хорлодог” зарчмыг дээдэлнэ.
- Өвөг дээдсийн өвлүүлсэн зан заншил, ёс суртахууны амин мөн чанарыг нандигнан хадгалж, төр ёсны зарчмыг түгээн дэлгэрүүлнэ.
- Салбарын суурь шинжтэй өөрчлөлтийг мэргэжлийн, салбарынхны үзэл бодолд суурилж хэрэгжүүлнэ.
- “Мууг устгахаас дутууг нь нөхсөн нь дээр. Аливаа юм муудсан шалтгаан нь дутагдсанд юм уу илүүдсэнд оршино. Дутагдсаныг нь нөхөөд илүүдсэнийг тэгшилбэл тэр юм угтаа сайн зүйл болдог” зарчмыг мөрдөж харилцааны хурдыг бий болгоно.

**“БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ 2024”
ТЭРГҮҮЛЭХ 12 ЗОРИЛТ**

Handwritten signatures in black ink.

000000001

1. Улс төрийн намын гишүүнчлэлээс болж, ард иргэд талцан хуваагдаж иргэдийн нийтлэг эрх ашиг хохирдог явдлыг арилгах, үндэсний үнэт зүйл дээр тулгуурласан улс төрийн харилцаанд шилжүүлэх чиглэн арилгана.
2. Орон нутагт тулгамдсан асуудлыг үндэсний хэмжээний цогц, оновчтой хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжүүлэх замаар бууруулна.
3. Төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтарч ажиллах бие даасан нөхцлийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.
4. Хүүхэд, залуучууд, ахмадуудыг нийгэм, байгаль зүйн шаардлага онцлогт нийцсэн бодлогоор хөгжүүлж, бүтээн байгуулалтад оролцох ажлыг зохион байгуулна.
5. НҮБ-н Тогтвортой хөгжлийн зорилт, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын холбогдох хууль, бодлого, зорилтын хүрээнд байгаль орчинд ээлтэй эрүүл орчныг орон нутагт бүтээн байгуулна.
6. Аймаг сумын хөгжлийн бодлогыг иргэдийн хурлын танхимаар хязгаарлахгүй шаардлагатай асуудлыг иргэдээр хэлэлцүүлж, санал асуулгын хэлбэрээр хэлэлцүүлж ажиллана.
7. Үндэсний үйлдвэрлэлийг гадаадын зах зээлд гаргах төрийн болон үндэсний маркетингийн цогц бодлогыг аймаг сумдын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
8. Тэргүүлэх салбаруудад бүтээлч, инновацид суурилсан санал санаачилгыг нэвтрүүлэхэд учрах хүнд суртлыг арилгах бодлогыг баримтлан ажиллана. Аймаг сумдын хөгжилд иргэдийн оролцоотойгоор орон нутгийн соёлыг дээшлүүлэх таатай нөхцлийг бүрдүүлж ажиллана.
9. Төрөөс олгох тусгай зөвшөөрлийг туршлагад суурилсан давуу байдлаас шинэ санаачилга, шинэ технологийг нэвтрүүлэхэд суурилсан өрсөлдөөнт талбарт шилжүүлэхэд чиглэж ажиллана.
10. Иргэнд тулгарч буй бэрхшээлийг дан ганц төрийн байгууллагаар шийдүүлдэг байдлыг өөрчлөх бодлогыг баримталж, нийгмийн хариуцлагын шинэ хандлага тогтоох ажлыг зохион байгуулна.
11. Төрийн үйлчилгээг шинэ арга барилд шилжүүлж ажиллах бодлогыг дэмжиж, Төрийн өндөр алба тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг бүх иргэдэд нээлттэй ил тод хүргэхэд анхаарч ажиллана.
12. Хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарыг орон нутгийн ард иргэдийн оролцоотойгоор нэмэгдүүлэх бодлогыг баримталж ажиллана. Бараа түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг олон улсын стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулна.

ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

А.Бархшув

Б.БАРХҮҮ



000000032